

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 31-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссийн дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНЦАЦРАЛТ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 31-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны ногдол ашиг хуваарилахгүй талаар батлах

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссийн дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК нь 2025 онд алдагдалтай ажилласан байх ба банкны өмнө хүлээсэн зээлийн гэрээний үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүй талаар хувьцаа эзэмшигчдэд таницуулсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНЦАЦРАЛТ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 31-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссийн дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ‘Хөнгөн бетон’ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:

а/ ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Баярхүү овогтой Наранзул
2. Баярхүү овогтой Наранцацралт
3. Баасанжав овогтой Мөнхцацралт
4. Баасанжав овогтой Алтанцэцэг
5. Гүндсамбуу овогтой Ганзориг
6. Аюурзана овогтой Чанцалдулам

б/ ТУЗ-ийн хараат бус гишүүд

7. Шаравсамбуу овогтой Энхтөр
8. Дамдиндагва овогтой Эрдэнэбилэг
9. Өлзийбаяр овогтой Ариунболд

2. ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгохгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНЦАЦРАЛТ